

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ХЭА-2026/074/НА-СТА-ТШЗ

Чингис хот 2026 он
Цахим хуудас: www.audit.mn

Тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112
Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390
Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Х.Еркегүл
Утас: 99040705
Цахим хаяг: erkegulkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг khentii@audit.gov.mn хаягаар авна уу

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	2
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	122
3.1 Төлбөрийн акт	12
3.2 Албан шаардлага	12
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОХНСАХ	Байгал орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2026.02.24 № 253
танай _____-ны № _____-т

ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
С.МӨНХДЭЛГЭР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

БОХНСАХ-ний зардлаас "Сэрсэн тал" арга хэмжээнд 10.0 сая төгрөгийг зарцуулж, зардлын эдийн засгийн ангиллыг баримтлаагүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, халаалтын шугамд холбогдон дулаан нийлүүлэх гэрээний дагуу халаалтын төлбөр төлдөг ч нэмэлтээр нүүрс худалдан авахад 4.8 сая төгрөг зарцуулж төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулж хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлтгэсэн, нөөцийн барааны 1.5 сая төгрөгийн үлдэгдлийг тоолоогүй, эд харилцагчтай тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, нөөцийн бараанаас тайлант онд санхүүгийн программаар 14.0 сая төгрөгийн зарлага гаргасан боловч эд хариуцагчийн тайлан гаргаагүй, зарцуулах шийдвэр, зарцуулалтыг нотлох анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэл хөтөлсөн зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс 1,375.8 сая төгрөгийн санхүүжилт авч 90 хувь буюу 1,244.6 сая төгрөгийг зарцуулж 131.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд 31.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, гүйцэтгэлээр 1.9 сая

төгрөгийг зарцуулж, жилийн эцсийн зарцуулагдаагүй үлдэгдэл 29.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, авлагаар тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитаар мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, урьдчилж төлсөн зардал, цалингийн зардлыг аудитын чиглэл болгон чухалчлан авч үзэв.

Аудитаар нийт 39.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 5.3 сая төгрөгийн 1 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, төсвийн зарцуулалттай холбоотой 1.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, төсвийг зориулалт бус зарцуулсан 10.0 сая төгрөг, анхан шатны баримтын бүрдэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 17.8 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 3 албан шаардлага, 4.8 сая төгрөгийн хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлтгэж, өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлагыг тус тус хүргүүллээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний хэрэгжилт 123 зорилтын хүрээнд 385 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, хэрэгжилт 87.2 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээш түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	131,907,721.93	174,658,435.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	217,636.93	29,544,200.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	217,636.93	-
335	Бусад авлага	-	29,544,200.00
3351	Байгууллагаас авах авлага	-	29,544,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	117,690,085.00	143,614,235.00
354	Хангамжийн материал	117,690,085.00	103,614,235.00
35410	Бичиг хэргийн материал	4,176,730.00	3,122,030.00
35420	Аж ахуйн материал	43,144,900.00	34,886,550.00
35440	Түлш, шатах тослох материал	2,940,000.00	3,262,000.00
35450	Барилгын засварын материал	-	580,600.00
35460	Хүнсний материал	234,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	67,194,455.00	61,763,055.00
35600	Мал амьтад	-	40,000,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	14,000,000.00	1,500,000.00
36300	Тэжээлийн нөөц	14,000,000.00	1,500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,033,135,967.56	3,651,473,872.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,033,135,967.56	3,651,473,872.78
392	Биет хөрөнгө	1,980,649,967.56	2,593,653,872.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,943,821,888.60	1,943,821,888.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(666,924,286.30)	(817,332,703.03)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	223,133,623.88	527,623,623.88
39204	Хуримтлагдсан элэгдэл	(149,978,623.72)	(183,860,040.31)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	481,620,571.27	433,153,708.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	(258,139,934.59)	(269,974,149.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,809,466.52	55,154,476.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	(65,451,915.72)	(43,307,381.61)
39214	Бусад үндсэн хөрөнгө	584,637,981.64	1,212,718,338.64
39215	Хуримтлагдсан элэгдэл	(192,878,804.02)	(264,343,889.18)
393	Биет бус хөрөнгө	1,052,486,000.00	1,057,820,000.00
39301	Програм хангамж	580,000.00	580,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(580,000.00)	(580,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,052,486,000.00	1,057,820,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,165,043,689.49	3,826,132,307.78
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	53,308,077.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	53,308,077.50
413	Өглөг	-	53,308,077.50
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	4,810,812.50
4136	Бусад өглөг	-	48,497,265.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	48,462,265.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	35,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,165,043,689.49	3,772,824,230.28
51	Засгийн газрын хувь оролцоо	3,165,043,689.49	3,772,824,230.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	454,409,802.20	459,743,802.20
51101	Өмч: - төрийн	454,409,802.20	459,743,802.20
512	Хуримтлагдсан үр дүн	2,625,837,019.24	3,228,283,560.03
51210	Өмнөх үеийн үр дүн	2,625,837,019.24	2,625,837,019.24
51220	Тайлант үеийн үр дүн	-	602,446,540.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зерүү	84,796,868.05	84,796,868.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,165,043,689.49	3,826,132,307.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,568,395,562.93	2,387,390,134.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	329,865,261.93	980,095,357.00
120	Нийтлэг татварын бус орлого	329,865,261.93	980,095,357.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	329,865,261.93	980,095,357.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	329,865,261.93	980,095,357.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,238,530,301.00	1,407,294,777.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,675,901.00	31,459,977.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,325,901.00	6,815,777.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	350,000.00	24,644,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,235,854,400.00	1,375,834,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,235,854,400.00	1,375,834,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,468,383,946.75	1,784,943,593.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,461,383,946.75	1,784,943,593.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,312,888,937.69	1,653,346,913.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	582,973,077.20	755,565,962.31
210101	Үндсэн цалин	298,216,105.89	402,757,151.51
210102	Нэмэгдэл	170,173,629.29	229,855,256.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,525,000.00	6,071,000.00
210104	Урамшуулал	27,139,759.45	46,990,403.13
210105	Гэрээт ажлын хөлс	84,918,582.57	69,892,151.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,087,045.59	91,550,104.36
210201	Тэтгэврийн даатгал	50,676,534.32	60,998,566.97
210202	Тэтгэмжийн даатгал	5,844,751.78	7,402,849.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,262,916.78	4,122,450.56
210204	Ажилгүйдлийн даатгал	2,859,241.13	3,979,336.93
210205	Эрүүл мэндийн даатгал	10,443,601.58	15,046,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,518,951.15	64,338,148.35
210301	Гэрэл, цахилгаан	19,379,605.15	29,273,152.35
210302	Түлш, халаалт	35,339,346.00	24,264,996.00
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	10,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	83,566,013.00	62,947,804.50
210401	Бичиг хэрэг	9,954,540.00	5,863,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,557,875.00	36,984,239.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,255,820.00	4,142,765.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	324,000.00	324,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,306,650.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	46,473,778.00	14,327,150.00
2105	Нормативт зардал	8,833,300.00	16,220,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	99,300.00
210502	Хоол, хүнс	8,833,300.00	14,580,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,541,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,510,000.00	9,214,136.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,310,000.00	690,000.00
210604	Урсгал засвар	2,200,000.00	8,524,136.00
2107	Томилолт, зочны зардал	16,418,000.00	24,420,000.00
210702	Дотоод албан томилолт	16,418,000.00	24,420,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	186,421,373.00	222,933,156.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	184,032,510.00	219,793,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	550,000.00	957,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	526,279.00	487,550.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	177,500.00	176,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	355,000.00	732,500.00
210807	Газрын төлбөр	780,084.00	786,756.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	298,561,177.75	406,156,901.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,184,900.00	65,668,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	80,000.00	387,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	266,296,277.75	340,101,451.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	148,495,009.06	131,596,679.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,211,040.00	400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,870,000.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	38,941,040.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,900,000.00	400,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	94,283,969.06	131,196,679.91
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	94,283,969.06	131,196,679.91
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,000,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	7,000,000.00	-
223001	Бусад хөрөнгө	7,000,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	100,011,616.18	602,446,540.79
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	100,011,616.18	602,446,540.79
223001	Бусад хөрөнгө	7,000,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	100,011,616.18	602,446,540.79

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,249,436,476.00	1,407,294,777.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	200,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	200,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	200,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,249,236,476.00	1,407,294,777.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,382,076.00	31,459,977.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,032,076.00	6,815,777.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	350,000.00	24,644,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,235,854,400.00	1,375,834,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,235,854,400.00	1,375,834,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,242,436,476.00	1,407,294,777.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,242,436,476.00	1,407,294,777.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,089,811,466.94	1,243,183,897.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	582,667,139.70	752,316,379.74
210101	Үндсэн цалин	325,094,198.86	346,788,008.69
210102	Нэмэгдэл	168,422,646.11	264,648,548.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,379,000.00	8,781,000.00
210104	Урамшуулал	21,896,900.00	48,148,797.84
210105	Гэрээт ажлын хөлс	64,874,394.73	83,950,024.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,200,483.09	94,042,800.00
210201	Тэтгэврийн даатгал	50,753,671.82	63,367,349.44
210202	Тэтгэмжийн даатгал	5,853,826.78	7,523,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,267,454.28	4,343,450.56
210204	Ажилгүйдлийн даатгал	2,863,778.63	4,067,880.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,461,751.58	14,740,720.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,404,601.15	66,200,148.35
210301	Гэрэл, цахилгаан	19,379,605.15	29,273,152.35
210302	Түлш, халаалт	26,224,996.00	26,126,996.00
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	10,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,606,021.00	40,736,977.00
210401	Бичиг хэрэг	4,906,700.00	3,333,000.00
210402	Тээвэр, шатахуун	23,758,901.00	29,165,777.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,255,820.00	4,105,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	721,000.00	324,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,963,600.00	3,809,000.00
2105	Нормативт зардал	1,698,750.00	1,807,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,698,750.00	1,807,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,285,000.00	24,497,086.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,551,500.00	14,485,000.00
210602	Тавилга	5,000,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	536,000.00
210604	Урсгал засвар	18,733,500.00	9,476,086.00
2107	Томилолт, зочны зардал	16,418,000.00	20,820,000.00
210702	Дотоод албан томилолт	16,418,000.00	20,820,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	230,111,872.00	195,542,006.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	227,338,009.00	192,381,950.00
210803	Даатгалын үйлчилгээ	550,000.00	957,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	526,279.00	487,550.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	177,500.00	176,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	740,000.00	732,500.00
210807	Газрын төлбөр	780,084.00	806,756.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,419,600.00	47,221,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,871,600.00	46,834,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,548,000.00	387,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	152,625,009.06	164,110,879.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,341,040.00	3,370,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,870,000.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	38,941,040.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,530,000.00	3,370,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	94,283,969.06	160,740,879.91
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	94,283,969.06	160,740,879.91
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,000,000.00</u>	=
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,000,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,000,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	7,000,000.00	-
223001	Бусад хөрөнгө	7,000,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(7,000,000.00)</u>	=
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	454,409,802.20	84,796,868.05	2,625,837,019.24	3,165,043,689.49
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	454,409,802.20	84,796,868.05	2,625,837,019.24	3,165,043,689.49
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	454,409,802.20	84,796,868.05	2,625,837,019.24	3,165,043,689.49
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	454,409,802.20	84,796,868.05	2,625,837,019.24	3,165,043,689.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	454,409,802.20	84,796,868.05	2,625,837,019.24	3,165,043,689.49
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	5,334,000.00			5,334,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	602,446,540.79	602,446,540.79
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	459,743,802.20	84,796,868.05	3,228,283,560.03	3,772,824,230.28

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/төгрөгөөр/	
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,375,834,800.00	1,244,638,120.09	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,375,834,800.00	1,244,638,120.09	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,369,753,300.00	1,241,268,120.09	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	752,342,500.00	752,316,379.74	
210101	Үндсэн цалин	345,000,000.00	346,788,008.69	
210102	Нэмэгдэл	265,546,000.00	264,648,548.87	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,628,500.00	8,781,000.00	
210104	Урамшуулал	52,368,000.00	48,148,797.84	
210105	Гэрээт ажлын хөлс	85,800,000.00	83,950,024.34	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,042,800.00	94,042,800.00	
210201	Тэтгэврийн даатгал	63,949,100.00	63,367,349.44	
210202	Тэтгэмжийн даатгал	7,523,400.00	7,523,400.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,761,700.00	4,343,450.56	
210204	Ажилгүйдлийн даатгал	3,761,700.00	4,067,880.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	15,046,900.00	14,740,720.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,167,400.00	66,200,148.35	
210301	Гэрэл, цахилгаан	40,245,600.00	29,273,152.35	
210302	Түлш, халаалт	29,121,800.00	26,126,996.00	
210303	Цэвэр, бохир ус	10,800,000.00	10,800,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	46,056,200.00	38,921,200.00	
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	3,333,000.00	
210402	Тээвэр, шатахуун	32,000,000.00	27,350,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,478,200.00	4,105,200.00	
210404	Ном, хэвлэл	265,000.00	-	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	780,000.00	324,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,533,000.00	3,809,000.00	
2105	Нормативт зардал	1,807,100.00	1,807,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,807,100.00	1,807,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,428,300.00	24,497,086.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,485,200.00	14,485,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943,100.00	536,000.00	
210604	Урсгал засвар	15,000,000.00	9,476,086.00	
2107	Томилолт, зочны зардал	25,500,000.00	20,820,000.00	
210702	Дотоод албан томилолт	25,500,000.00	20,820,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	281,611,200.00	195,442,006.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	277,488,200.00	192,281,950.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	622,800.00	-	
210803	Даатгалын үйлчилгээ	1,014,300.00	957,250.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	536,400.00	487,550.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	245,600.00	176,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	740,400.00	732,500.00	
210807	Газрын төлбөр	963,500.00	806,756.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,797,800.00	47,221,500.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,248,900.00	46,834,500.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,548,900.00	387,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,081,500.00	3,370,000.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,081,500.00	3,370,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,081,500.00	3,370,000.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,375,834,800.00	1,244,638,120.09	
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,375,834,800.00	1,244,638,120.09	
132001	Орон нутгийн төсвөөс	1,375,834,800.00	1,244,638,120.09	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,459,977.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,915,777.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,915,777.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-
210604	Урсгал засвар	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,544,200.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	29,544,200.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	31,459,977.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,459,977.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,815,777.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,644,200.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,334.0 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийв. Үүнд:

1. ОНӨГ-ын шийдвэрээр шилжиж ирсэн 5,334.0 мянган төгрөгийн газрыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн.

Аудитаар нийт 33,726.5 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс 1,124.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 27,800.0 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 3 албан шаардлага, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил давтагдсан 4,802.0 мянган төгрөгийн зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

3.1 Төлбөрийн акт:

1. Ажилласан өдөр, ээлжийн амралтын өдрийг давхардуулан тооцож 1,124.5 мянган төгрөгийн цалин илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

3.2 Албан шаардлага

1. БОХНСАХ-ний зардлаас “Сэрсэн тал” арга хэмжээнд 10,000.0 мянган төгрөгийг зарцуулж, зардлын эдийн засгийн ангилалыг баримтлаагүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолыг зөрчсөн байна.
2. Баялаг говь ХХК-д цэвэрлэх байгууламжийн төхөөрөмж засварт 950.0 мянган төгрөг, нийтийн бие засах газрын засварт 1,350.0 мянган төгрөг, нийт 2,300.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан боловч эвдрэл, гэмтлийг тогтоосон акт үйлдээгүй, гэрээнд гүйцэтгэх ажлыг тусгаагүй, гэрээг дүгнээгүй, хийсэн ажлын тайлан байхгүй зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэл хөтөлж бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог;”, 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалт;
3. Тайлант онд санхүүгийн тайлангаар нөөцийн бараанаас 14,000.0 мянган төгрөгийн барааг анхан шатны баримтгүй зарцуулсан, эд хариуцагчийн тайлан гаргаагүй,

жилийн эцэст 1,500.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тоолоогүй, тооцоо бодож, үлдэгдлийг баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. 14 дүгээр зүйлийн 14.3-д “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх; 14.3.2. журналд бичих; 14.3.3. дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх; 14.3.4. ажил, гүйлгээний мэдээ гаргах; 14.3.5. санхүүгийн тайлан гаргах”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн тул зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

4. Төвийн халаалтын шугамд холбогдон дулаан нийлүүлэх гэрээний дагуу халаалтын төлбөр төлдөг ч нэмэлтээр нүүрс худалдан авахад 4,802.0 мянган төгрөг зарцуулж, хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлтгэн, төсвийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулдаг зөрчил давтагдаж, өмнөх оны аудитаар өгсөн зөрчил арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн санхилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн бүртгэл	1	5,334.0			1	5,334.0						
Дүн	1	5,334.0	-	-	1	5,334.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа материалын бүртгэл, зарцуулалт	1	15,500.0			1	15,500.0						
Төсвийг зориулалт бус зарцуулсан	1	10,000.0			1	10,000.0						
Төсвийн анхан шатны баримтгүй зарцуулдаг	1	2,300.0			1	2,300.0						
Цалин олголт	1	1,124.5	1	1,124.5								
Өмнөх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчил давтагдсан	1	4,802.0							1	4,802.0		
Дүн	5	33,726.5	1	3,424.5	3	27,800.0	-	-	1	4,802.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Зөрчилгүй	0	0						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Зөрчилгүй								



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 67-А2370449

Чингис хот

ХЭА-2026/074/НА-СТА-ТШЗ

Г

Төлбөр барагдуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 1 ажилтанд ээлжийн амралтын хугацаанд 1,124,500.00 /нэг сая нэг зуун хорин дөрвөн мянга таван зуун/ төгрөгийн цалин давхардуулан тооцон олгож, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү олгосон 1,124,500.00 /нэг сая нэг зуун хорин дөрвөн мянга таван зуун/ төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ЗДТГ-ын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч Т.Энхсайхан нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ж.ГАНБААТАР
Х.ЕРКЕГҮЛ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 203-А2370449

Чингис хот

ХЭА-2026/074/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд санхүүгийн тайлангаар нөөцийн бараанаас 14,000,000.00 /арван дөрвөн сая/ төгрөгийн барааг анхан шатны баримтгүй зарцуулсан, эд хариуцагчийн тайлан гаргаагүй, жилийн эцэст 1,500,000.00 /нэг сая таван зуун/ төгрөгийн үлдэгдлийг тоолоогүй, тооцоо бодож, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. 14 дүгээр зүйлийн 14.3-д "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ", 14.3.1-д "анхан шатны баримт бүрдүүлэх; 14.3.2. журналд бичих; 14.3.3. дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх; 14.3.4. ажил, гүйлгээний мэдээ гаргах; 14.3.5. санхүүгийн тайлан гаргах", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1 "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.2-д "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нөөцийн барааг анхан шатны баримтгүй зарцуулдаг, тооллогыг чанаргүй гүйцэтгэдэг, эд хариуцагчийн тайлан гаргадаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ЗДТГ-ын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч Т.Энхсайхан нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Х.ЕРКЕГҮЛ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 202-А2370449

Чингис хот

ХЭА-2026/074/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баялаг говь ХХК-д цэвэрлэх байгууламжийн төхөөрөмж засварт 950,000.00 /есөн зуун тавин мянган/ төгрөг, нийтийн бие засах газрын засварт 1,350,000.00 /нэг сая гурван зуун тавин мянган/ төгрөгийг тус тус зарцуулсан боловч эвдрэл, гэмтлийг тогтоосон акт үйлдээгүй, гэрээнд гүйцэтгэх ажлыг тусгаагүй, гэрээг дүгнээгүй, хийсэн ажлын тайлан байхгүй зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэл хөтөлж бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1 "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэж төсвийн хөрөнгийг зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг засаг даргын тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч Т.Энхсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН!

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Х.ЕРКЕГҮЛ



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25

Дугаар 204 - А2370449

Чингис хот

ХЭА - 2026/074/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас "Сэрсэн тал" арга хэмжээнд зориулж 10,000,000.00 /арван сая/ төгрөгийг зарцуулж, зардлын эдийн засгийн ангиллыг баримтлаагүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ЗДТГ-ын дарга С.Мөнхдэлгэрт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

ЖТАНБААТАР

Х.ЕРКЕГҮЛ





**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25

Дугаар 205 - А2370449

Чингис хот

ХЭА-2026/074/НА-СТА-ТШЗ

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төвийн халаалтын шугамд холбогдон дулаан нийлүүлэх гэрээний дагуу халаалтын төлбөр төлдөг ч 4,802,000.00 /дөрвөн сая найман зуун хоёр мянга/ төгрөгийн нүүрс худалдан авч хэрэгцээ, шаардлагагүй эд хөрөнгө бэлтгэн төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулдаг зөрчил давтагдаж, өмнөх оны аудитаар өгсөн зөрчил арилгах албан шаардлагыг биелүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно".

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засаг даргын тамгын газрын дарга С.Мөнхдэлгэрт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг сумын Засаг дарга С.Ганбат-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Х.ЕРКЕГҮЛ

